СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 11 сарын 13 өдөр Дугаар 15/32-01 Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 09 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ДА-2026/17/ҮА дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-н 2025, 2026 оны 1-9 дүгээр сарын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар худалдан авалтын 39,303,200.0 (Гучин есөн сая гурван зуун гурван мянга хоёр зуу) төгрөгийн 37 баримтыг бөөн дүнгээр бүртгэж санхүүгийн тайланд тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалт хийхдээ цахим төлбөрийн баримтад бараа, ажил үйлчилгээг бөөн дүнгээр бус нэр төрөл, тоо ширхэг, нэгж үнээр нь баримтыг үүсгүүлэн санхүүгийн тайланд тусгаж байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг "Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-н захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул нарт даалгав.

4326007061

3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Т.ОДСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СҮХБААТАР СУМЫН "ЦАГААН-ЭРЭГ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-Н ЗАХИРАЛ Д.ЦЭЛМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ Ц.АРИУНЗУЛ

4326007061

د ښاغلي ډاکټر محمد ګلزار ګډون د ۲۰۲۵ کال د ډسمبر د ۱۵ نېټې د ماسپښین ۳:۳۰ بجو د ګډون ژمنه کوي.

د ګډون ژمنه کوونکي: ډاکټر محمد ګلزار

۲۰ ـ ۲۰۲۵ د لړم ۲۵ نېټه د ۲۰۲۵ د لړم ۲۵ نېټه د ۲۰۲۵ د لړم ۲۵ نېټه د